



XXI ЗУУНЫ МАЛЧИН

МОДУЛЬ 9

АМЖИЛТ БҮТЭЭЛ, АШИГ ОРЛОГО



Хөдөө Аж Ахуйн
Үйлдвэрлэлд Шинжлэх
Ухааны Ололт Нэвтрүүлэх Төв



Олон Улсын Хөдөлмөрийн
Байгууллага


ХХІ ЗУУНЫ МАЛЧИН

МОДУЛЬ 9. АМЖИЛТ БҮТЭЭЛ, АШИГ ОРЛОГО



УЛААНБААТАР

2013



ТАНИХ ТЭМДЭГ



Уншаарай



Анхаараарай



Хамтран ажиллаарай



Хүүхэдтэйгээ ярилцаарай



Өөрийгөө үнэлээрэй



Бичээрэй

Модуль 9. АМЖИЛТ БҮТЭЭЛ, АШИГ ОРЛОГО

Боловсруулсан:

Д.Гүндэгмаа

Хянан тохиолдуулсан:

И.Ханымхан, Ч.Нилбаатар, Н.Монголмаа

Зураач:

Г.Амарсанаа

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Н.Эрдэнэ



АГУУЛГА

1. Удиртгал.....	4
2. Малчинтанд орлогоо нэмэгдүүлэх боломж байна.....	6
3. Утас ээрч, ширмэл ширэх дасгал ажил.....	14
4. Нэхий элдэх дасгал ажил.....	28
5. Шар сүү, дайвар бүтээгдэхүүнээр төрөл бүрийн хоол хүнс бэлтгэх дасгал ажил.....	36
6. Амжилт бүтээл.....	41
7. Ашигласан материал.....	44

МОДУЛЬ 9. АМЖИЛТ БҮТЭЭЛ, АШИГ ОРЛОГО

Зорилго: Малчин айл өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломжийг ашиглах мэдлэг, чадвар эзэмшин, үнэнч шудрагаар ашиг орлого олох хүсэл эрмэлзлэлийг өдөөх зорилготой.

Энэхүү модулийг үзэх явцад Та:

- Өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломжийг сайн ашиглах,
- Малчны бүлэг, хоршоонд нэгдэн хамтарч ажиллах нь ашиг орлогоо нэмэгдүүлэх илүү боломжтой гэдгийг улам гүнзний ойлгох,
- Малчин өрхийн төсөв, орлого зарлагын бүртгэл хөтлөх, үр ашиггүй зардлыг багасгах,
- Утас ээрэх, ширдэг ширэх, арьс элдэх гэх мэт дасгал хийх
- Ашигладаггүй болон бага ашигладаг нөөцийг (ноолуур, ноосонд анхан шатны боловсруулалт хийх, бог малаа саалинд бүрэн хамруулах, дайвар бүтээгдэхүүнээр төрөл бүрийн амтат хоол зууш, шар сүүгээр бүтээгдэхүүн хийх гэх мэт) ашиглах,
- Гар ажиллагааг хөнгөвчлөх бүтээмж өндөртэй тоног төхөөрөмжийг судлах, ашиглах,
- Түүхий эд, бүтээгдэхүүнээ ашигтай борлуулах арга замыг хайх хүсэл эрмэлзлэлтэй болно.

1.УДИРТГАЛ



-За, Ганаа минь, бид нар нэлээн л ном үзлээ. Мал маллагааны арга ухаанаас бага сага юм сурч байна уу?

-Юм юмны захтай боллоо. Урьд нь анзаардаггүй, мэддэггүй юм их байжээ. Цаашдаа ч сурах юм их байгааг сайн ойлгож авлаа.



-За энэ чинь л их олз доо. Хүн өөрөө л хүсвэл сурч чадахгүй юм гэж байхгүй. Энэ удаа малчин айл ашиг орлогоо хэрхэн нэмэгдүүлэх боломжийн талаар үзнэ.



“Явдаг үйлдвэр” гэгддэг буянт малынхаа ашиг шимийг нь бүрэн хүртэж чадвал малчин хүн чинээлэг амьдарч болно оо. Малчдад төр засаг ч анхаарч, бидний амьдрал ч дээшилж байна шүү дээ. Шинэ тутам мал маллаж байгаа та нар шиг залуус “хөл дээрээ бостол”-оо жаахан тэвддэг л байх. Мал маллаж амьдрахаар шийдсэн бол давах л хэрэгтэй.

Малаас хаях юм үгүй. Мах, сүү, ноос ноолуур, арьс шир, гэдэс цувдай, толгой шийр, мөлжөөд хаясан яс, ялгадас нь хүртэл ямар ч мундаг эрдэмтэн, ямар ч үйлдвэр бий болгож чадахгүй, дахин давтагдашгүй түүхий эд юм. Аргал хоргол гэхэд үнэгүй, байгаль орчинд хор нөлөөгүй ямар амар түлш байна даа. Хөрөөднө, хагална гэх биш, амар шүү.

Монгол адууны чөмөгний яснаас гаргаж авсан “Монмажун” хэмээх кальцийн нэмэлт бүтээгдэхүүн өдгөө Солонгост эрэлт хэрэгцээтэй юмны нэг гэсэн. Манай махны захуудаас хэдхэн төгрөгөөр худалдаж авсан ясаа Монгол дахь салбар үйлдвэртээ хагас боловсруулж, Солонгост хийсэн бүтээгдэхүүн нь худалдаанд гарахдаа 1 хайрцаг нь 175 мянган төгрөгийн үнэд хүрдэг гээд бод доо. Дээр үед уг нь манайхан малынхаа ясыг буцалгаад, тосоор нь **ядаж л барааны саван** хийчихдэг байж. Нэг хэсэг манай сумын бараг бүх айл гэртээ барааны саван хийдэг байсан. Адууны дэл, сүүлээр гоо сайхны багс, бийр хийдэг жижиг үйлдвэрүүд нэг хэсэг ажиллаж байгаад зах зээлийн шуурганд унасан гэдэг юм. Цагтаа тийм багс, бийрийг Японд хүртэл гаргадаг байсан бол одоо ямар ч боловсруулалтгүйгээр тэр чигт нь урд хөрш рүү зөөж, эргээд Хятадаас өндөр үнээр багс, бийрээ худалдаж авдаг болсон гэнэ.

- Сонин түүх байна. Та ийм сонин юмыг хаанаас мэдэж авдаг байна аа?
- Телевиз үзнэ, радио сонсоно, ном сонин уншина. Би тэгээд та нарыг бодвол их завтай хүн. Тэгээд ч та нар шиг солонгос кино үзэж хамаг цагаа барах биш.
- Гэртээ хийж байсан барааны саван юмны хирийг сайн арилгах уу?
- Арилгана аа. Саван шиг л саван. Би ч хүртэл хийж байсан. Жижиглэж хуваахгүй том томоор нь хатаагаад хөнжлийнхөө даавууг хөмөргөж байгаад савандаж угаадаг байж билээ. Тэр үед манай суманд нэг казак малын эмч ирж ажилласан юм. Тэдний эхнэр бид нарт саван хийхийг зааж өгч байлаа. Бид нар Жазираагаас казак хатгамал, хонины ноосоор битүү эсгий оймс дарах гэх мэт их юм сурсан. Одоо хотоос төслийнхөн ирж заадаг гэсэн. Манай малын эмчийнх байнга цэвэрхэн дулаахан, идээ унд элбэг. Жазира их сайхан зантай, алиа. Бид тэднийд цуглах их дуртай. Хэсэг ажиллаж байгаад нутаг руугаа шилжиж нүүхэд нь бидний хэдэн найз бүсгүйчүүд уйлаад л үдэж байлаа. Одооныхоор бол эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллага ч юм уу, хамтлагч юм уу сайн дураараа нэгдсэн нэг жижиг бүлэг бий болсон байлаа.
- Манай Болороо малчны бүлгийн хүүхнүүдтэйгээ нийлж утас ээрэх, дээс томох, ширдэг ширэх, арвайн гурил хийх зэрэг ажил хийнэ. Хийсэн юмаа эхлээд Зоригт ахын дэлгүүрт тавьж худалдана. Орлого сайн байвал сумын төвд “Малчны дэлгүүр” нээнэ гэж төлөвлөөд байгаа.




- Энэ чинь ёстой зөв санаа. Сумын төвийн тэр олон дэлгүүрт амархан урагдаж ганддаг хятад хувцас, чихэр боов төдийхнөөс өөр юм бараг харагдахгүй юм. Тэмээний ноосон утас, гэрийн оосор, бүслүүр, дээс, хазаар ногт байдаггүй байх аа?... Ажил муутай зарим нь малаа бараг **төмөр утсаар оосорлох** дөхөж байна. Малаа оосорлох бурантаг, дээс томж, сур элдэж суух байтугай дээлээ оёод өмсөх хүн ховордсон байна шүү. Дээл, дээс, эсгий, арьс, нэхий, сурнаас илүү монгол малчин, мал хоёрт ээлтэй юм ч байхгүй дээ. Малчны бүлэг гэснээс бүлэг байгуулах төлөвлөгөөгөө хийж байгаа юу?
- Цаасан дээр бол Болороо бид хоёр бүлгээ байгуулаад байгаа. Даалгавраа одоо шалгах уу?
- Үгүй гэрт чинь очиж шалгана. Одоо энэ номоо үзээд хийж сурах юмыг нь хийж бай. Бид нар ч номоо үзээд дуусаж байгаа. Сургалтын дараах тайлан-үзэсгэлэн сумын төвд болох юм гэсэн шүү. Та хоёр үзэсгэлэнд тавих юмаа бэлтгэж байгаарай. Нөгөө Болдоо, Урнаа хоёрт зааж өгч байгаа юу? Тэд нарыг бас үзэсгэлэнд тавих юмаа бэлтгэ гэж хэлээрэй.
- Өө, тэр хоёр ёстой идэвхтэй сурч байгаа. Манай бүлэгт орно гэсэн.

2.МАЛЧИН ТАНД ОРЛОГОО НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ БАЙНА

Малчдын орлогын гол эх үүсвэр нь мал аж ахуй. Гэвч энэ эх үүсвэр нь байгаль, цаг уурын нөхцөл байдал, малын ашиг шим, үүлдэр угсаа, маллагааны технологи, малчны ажлын туршлагаас шалтгаалан тогтвортой бус байх хандлагатай байдаг. Иймээс малчин Таны орлого тогтмол, төрөл бүрийн эх үүсвэртэй байх олон боломж байгаагийн заримыг нь дурдая. Хүн ухаантай ч хэлэхээс наашгүй гэдэг дээ...

1. Малчин өрхийн орлогын гол эх үүсвэр болох ноос ноолууртаа анхан гатны боловсруулалт хийж илүү үнэ хүргэх боломжтой. Жишээ нь, хөдөө аж ахуйн биржээр арилжих ямааны ноолуурыг дараах шаардлагыг хангаж бэлтгэвэл илүү үнэ хүрнэ. Үүнд:
 - Жигд атираатай, уян зөөлөн, өт хорхойд идэгдээгүй, хэлбэрээ алдаагүй байх,
 - Хогт хольцын хэмжээ нийт жингийн 10 хувиас хэтрэхгүй байх,
 - Хэвийн чийглэг 12 хувиас ихгүй байх,
 - Хялгас агууламжийн хэмжээ 20 хувиас бага байх
2. Малынхаа түүхий эдээр бүтээгдэхүүн хийж орлого олох боломжтой. Жишээ нь, адууны дэл, сүүл, сарлагийн савгаар гэрийн бүслүүр, оосор бүч, хананы боолт, унины сагалдрага хийгээд борлуулахад 1 кг дэл сүүл, саваг зарахаас 2-3 дахин илүү орлого олно. Ахар хурганы ноосоороо нарийн цагаан эсгий хийгээд ширмэл болгож зарахад л 100 мянгаас дээш төгрөгний орлого олно. Идэшний үхрийнхээ тал ширээр бугуйл хийгээд зарахад 120 мянган төгрөг олно. Жишээ нь, Өвөрхангай




аймгийн Хужирт сумын эмэгтэйчүүдийн бүлэг дээс томох бизнесээр амжиргаагаа дээшлүүлж байгаа гэнэ.



Зураг 1. Өвөрхангай аймгийн Хужирт сумын эмэгтэйчүүд дээс томж байгаа нь

ажиллагаагаар бүтээгдэхүүн үйлдвэрлэж амжилтад хүрэх хүндрэлтэй. Сүүлийн үед хөдөө аж ахуйн салбарын гар ажиллагааг хөнгөвчлөх тоног төхөөрөмж бүтээж нийлүүлдэг газрууд бий болж байна. Тэдгээрийг худалдаж авахад мэдээж зээл, тусламж хэрэгтэй. Жишээг зураг 2,3-аас харна уу.




Зураг 2. Ноосоор дээс, хошлон хийдэг гар төхөөрөмж, 2012 он. Эх сурвалж: <http://zuvluh.mn/equipment/equipment>



Зураг 3. Ноосоор дээс, хошлон хийдэг цахилгаан төхөөрөмж, 2012 он. Эх сурвалж: <http://zuvluh.mn/equipment/equipment>

Хөдөлмөрөө хорших гэж юу вэ? Ойролцоо нутагладаг хэдэн айл бүгдээрээ худаг гаргах хэрэгцээтэй байгаа бол нэг нэгээрээ хэдэн жижиг худаг гаргах биш тал талаасаа хөрөнгө, хүчээ нэгтгээд, нэг сайн худагтай болж хамтраад ашиглана гэсэн үг.



Хоршиж нэгдэн ажиллавал мал, малын гаралтай бүтээгдэхүүний борлуулалтын орлогоо дунджаар 30%-иар нэмэгдүүлж, тээвэрлэлт болон бусад зардлаа 23%-иар бууруулах, малчид өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг орон нутгийн үнээс 32%-иар хямдаар хэрэглэх боломжтой байгааг судлаачид тогтоосон байна.

Хөдөлмөрөө дагнах гэж юу вэ? Дээс томох, ширмэл ширэх, сур элдэх гэх мэт олон төрлийн ажлыг айл бүр тус тусдаа хийх биш аль чаддаг нь сураа элдэж, дээсээ томж бүлгийн гишүүдийнхээ хэрэгцээг хангаж, дутуугаа гүйцээж илүү гарсныг зарж борлуулна гэсэн үг. Жишээ нь:

- **Нэг дэх бүлэг нь** сүү цагаан идээ боловсруулах, ингэ, гүүний сүү, саамаар ундаа, хоормог, айраг хийж савлах, шар сүүг савлаж эмчилгээний зориулалтаар ашиглахаар бэлтгэх,
- **Хоёр дахь бүлэг нь** ямааны ноолуур, сарлагийн хөөвөр, тэмээний эм ноос зэргийг самнаж угааж, ээрмэлийн үйлдвэрүүдэд нийлүүлэх, ямааны хялгас, үхэр, адууны хөөвөр, хонины ноосоор эсгий, эсгий эдлэл, хурганы ноосоор өвлийн дулаан гутал хийх, тэмээний зогдор, сарлагийн саваг, адууны дэл сүүлээр дээс томох, утас ээрэх, шүүр хийх,
- **Гурав дахь бүлэг нь** том мал, төлийн арьс шир элдэх, хувцас оёх, сур хийх, эвэр туруугаар цавуу хийж барилгын үйлдвэрлэлд нийлүүлэх,
- **Дөрөв дэх бүлэг нь** төмс хvнсний ногоо, буудай, арвай тариалж арвайн гурил хийх, байгалийн өгөөж самар, жимс түүж нөөшлөх, зөгий үржүүлэх,
- **Тав дахь бүлэг нь** барилга угсралт засварын ажил хийх, гар худаг гаргах, мах ногооны зоорь, хашаа хороо барих, тоосго шохой шатаах, малын тэжээл бэлтгэх жижиг цех, үйлдвэр байгуулж зах зээлээ өргөтгөн сум орноо хөгжүүлэн иргэдийн амьжиргааг өөд татах боломж байна.

4. Гарын доорх нөөцийг ашиглаж орлого олох боломж бас байна. Үүнд:

Байгалийн нөөц ашиглах (жимс, самар, сонгино, халиар, жууцай, эмийн ургамал, давс, хужир),

Хадлан, гар тэжээл бэлтгэх (лууль, шарилж, халгай, хамхууль, хүнхээл, агь гэх мэт),

Гахай, шувуу, туулай үржүүлэх (нутгийн тахиа, бор галуу, цацагт хяруул, нутгийн гахай гэх мэт)

5. Малчид үйлдвэрлэл эрхлэх болон технологи, арилжааны сургалтанд хамрагдах нь ашиг орлогоо нэмэгдүүлэх чухал алхам юм.




6. Орлого олох нөөц боломжийг бүрэн ашиглаж ашгаа нэмэгдүүлэх боломж байна. Жишээ нь, бог малыг саалинд бүрэн хамруулах, сарлагийн хөөвөр, адууны дэл, сүүл, хонины ноосыг бүрэн ашиглах, гэр бүлийн гишүүн бүр өөртөө тохирсон ажилтай, өсөж хөгжих эрмэлзлэлтэй болох гэх мэт.
7. Малын үүлдэр угсааг сайжруулж ашиг олох боломж байна. Заавал гадаадын маллагаа, арчилгаа, тэжээллэгийн нарийн ажиллагаа шаардсан, эмзэг малаар бус өөрийн орон нутагт дасан зохицсон шилмэл омог, үүлдрийн хээлтүүлэгч, хээлтэгч ашиглах, эсвэл бусдаас худалдан авах замаар малынхаа үүлдэг угсааг сайжруулж, ашиг шимийг нь нэмэгдүүлэх боломж байгааг анхаараарай. Ямар үүлдрийн малыг, ямар аймагт үржүүлдэг талаар модуль 3-т үзсэнийг санаж байна уу? Хэрвээ санахгүй бол эргэж хараарай.
8. Үржлийн зориулалтаар өсвөр малыг өсгөж, борлуулан ашиг орлогоо нэмэгдүүлэх боломж бас бий. Сүүлийн жилүүдэд зарим малчид сайн чанарын мал сүрэг өсгөхийн зэрэгцээ сүргийн нөхөн үйлдвэрлэлд шаардлагатай төлөөс бусад өсвөр малыг борлуулах нь элбэг байна. Ингэснээр өвөл, хаврын хахир хатуу улиралд учирч болох эрсдлийг бууруулах, бэлчээрийн ашиглалтыг сайжруулах, тэжээлийн зардлыг бууруулах, орлогыг тогтворжуулах боломжтой болж байна.
9. Малаа шахаж бордоод илүү үнэд хүргэж зарах боломжтой.
10. Малдаа шаардлагатай тэжээлийг тооцоод, өөрсдөө бэлтгэх боломжтойг нь бэлтгэж, өвс, тэжээл худалдаж авах мөнгөө хэмнэх боломжтой.
11. Зардлын төрлийг хянаж, үр ашиггүй зардлыг бууруулах хэрэгтэй. Гэхдээ энэ нь шаардлагатай зүйлсийг өөрөө өөрөөсөө харамлана гэсэн үг биш юм.
12. Өрхийн төсвийг зохиож, мөрдөж сурвал, ашиггүй зүйлд мөнгөө үрэхээс урьдчилан сэргийлэх болно. Үүний тулд орлого, зардлаа бүртгэж дүгнэлт хийх хэрэгтэй.

Малчин өрхийн орлого нь дараах 2 эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

1. **МАЗ-н орлого.** Энэ төрлийн орлого нь мал, мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, арьс шир, ноос ноолуур зэргийг зах зээлд худалдан борлуулах замаар олох орлогоос бүрдэх бөгөөд орлогын хэмжээ нь тухайн өрхийн малын тоо, төрөл, гарах түүхий эд, бүтээгдэхүүний нэр, төрөл, тоо, хэмжээ, ямар үнээр борлуулсан зэргээс хамааралтай.
2. **МАЗ-н бус орлого.** Бусдад гэрээгээр ажил гүйцэтгэсний хөлс буюу цалин, төрөөс олгож буй төрөл бүрийн тэтгэвэр тэтгэмж, өрхийн хэмжээний жижиг үйлдвэрлэл эрхлэх, байгалийн баялаг ашиглах замаар олох орлого болон МАЗ-н бус бусад бүтээгдэхүүн, үйлчилгээний орлогоос бүрдэнэ.

Зардлын бүтцийг бүртгэснээр ямар төрлийн зарлага давамгайлж байгаа, мал аж ахуйдаа хир зэрэг хөрөнгө оруулж байгаа, үйлдвэрлэлээ өргөтгөх, хуримтлал бий болгох ямар боломж буйг мэдэх, цаашид авах арга хэмжээг төлөвлөхөд чухал



нөлөөтэй. Зарлагаа хянах үүднээс нийт зардлаас хамгийн өндөр хувь эзэлж буй хэсэгт анхаарах шаардлагатай.

Малчин өрхийн зардлыг дараах байдлаар бүлэглэж болох юм. Үүнд:

МАН-н зардал:

- Тэжээл,
- Мал эмнэлэг,
- Малын даатгал,
- Зохиомол хээлтүүлэг хийлгэх зардал,
- Хашаа хороо,
- Малын хөлийн татвар,
- Хээлтэгч, хээлтүүлэгч авах,
- МАН-н тоног төхөөрөмж;
- Хэрвээ гэрээт болон туслах малчинтай бол тэдгээрийн цалин гэх мэт

Хөрөнгө оруулалт

- Цахилгаан хэрэгсэл худалдан авах, засах,
- Цахилгаан үүсгүүр авах,
- Гэр байшин барих, засах,
- Машин техник авах, засах,


Нийгмийн үйлчилгээ

- Хүн эмнэлэг,
- Боловсрол (цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дээд сургууль)
- Эрүүл мэнд, нийгмийн даатгал,
- Баяр ёслол (цагаан сар, хурим),

Хэрэглээний зардал:

- Хоол хүнс,
- Хувцас,
- Халаалт (мод, нүүрс, аргал, хөрзөн)
- Харилцаа холбоо,
- Шатахуун,
- Өргөн хэрэглээний бараа

Малчин Танд өрхийнхөө орлого, зарлагыг бүртгэж, ашиггүй зардлыг багасгахад туслах нэгэн дэвтрийг Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны харъяа Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд



шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төвийн эрдэмтэд, мэргэжилтнүүд санал болгож байна. Та “Малчин өрхийн орлого, зарлагын бүртгэл, үр ашгийн тооцооны дэвтэр”-ийг сар бүр бүртгээд, хяналт тавиад үзээрэй. Дэвтрийг сумынхаа Мал эмнэлэг, үржлийн тасгаас асуугаарай.




Дасгал 1. Өрхийнхээ орлого, зардлыг бүртгээрэй.

САНАМЖ: Хүснэгтэд бичээгүй орлого буюу зардал байвал бусад гэсэн нүдэнд нэмж бичээрэй.

ОРЛОГЫН БҮРТГЭЛ

... оны ... сар


Бүтээгдэхүүний нэр төрөл		Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт
МАА-н орлого	Мал				
	Үүнд	Үхэр			
		Адуу			
		Тэмээ			
		Хонь			
		Ямаа			
	Мах				
	Үүнд	Үхэр			
		Адуу			
		Тэмээ			
		Хонь			
		Ямаа			
	Сүүн бүтээгдэхүүн				
	Үүнд	Үхэр			
		Адуу			
		Бусад			
	Ноос, ноолуур, хялгас, хөөвөр				
	Үүнд	Үхэр			
		Адуу			
		Тэмээ			
		Хонь			
		Ямаа			
	Арьс, шир				



	Үүнд	Үхэр				
		Адуу				
		Тэмээ				
		Хонь				
		Ямаа				
БҮГД						
МАА-н бус орлого	Цалин					
	Үүнд	Хөлсөөр мал хариулах				
		Хашаа хороо манах				
		Ямаа самнах				
		Хонь хяргах				
		Хурдан морь уях				
		бусад				
	Бизнесийн орлого					
	Үүнд	Түлээ, хөрзөн бэлтгэх				
		Жуулчдад үйлчлэх				
		Байгалийн баялаг ашиглах				
		Хадлан худалдах				
		бусад				
	Тэтгэвэр, тэтгэмж					
	Үүнд	Хүний хөгжлийн мөнгө				
		Тэтгэвэр, тэтгэмж				
		Бусад				
	БҮГД					

ӨРХИЙН ЗАРДЛЫН БҮРТГЭЛ

Зардлын төрөл		Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт
Хөрөнгө оруулалт					
Үүнд	Цахилгаан хэрэгсэл авах, засах				
	Цахилгаан үүсгүүр авах				
	Хашаа байшин, гэр барих, засварлах				
	Машин техник худалдан авах, засах				




Нийгмийн үйлчилгээ						
Үүнд	Хүн эмнэлгийн үйлчилгээ, эм тариа					
	Ерөнхий боловсрол эзэмших					
	Дээд боловсрол унзүмших					
	Баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулах					
	Бусад					
Хэрэглээний зардал						
Үүнд	Түлш					
	Шуудан, харилцаа холбоо					
	Хүнсний бүтээгдэхүүн					
	Үүнд	Гурил				
		Будаа				
		Элсэн чихэр				
		Хүнсний ногоо				
		Ургамлын тос				
		Бусад				
	Хувцас					
	Үүнд	Гутал				
		Хүрэм				
		Цамц				
		Бусад				
	Ариун цэврийн бүтээгдэхүүн					
БҮГД						

ӨРХИЙН ҮР АШГИЙН БҮРТГЭЛ

... оны ... сар

Д/д	Үзүүлэлт	Нийт
1	НИЙТ ОРЛОГО	
1.1	Мал аж ахуйн орлого	
1.2	Мал аж ахуйн бус орлого	





2	НИЙТ ЗАРДАЛ	
2.1	МАН-н зардал	
2.2	Хөрөнгө оруулалтын зардал	
2.3	Нийгмийн үйлчилгээ	
2.4	Хэрэглээ	
3	АШИГ	

3.УТАС ЭЭРЧ, ШИРМЭЛ ШИРЭХ ДАСГАЛ АЖИЛ

Эсгий эдлэл. Эсгийгүйгээр монголчуудын амьдралыг төсөөлөх аргагүй. Монголчууд эсгийгээр орд өргөө, өрх үүд, олбог дэвсгэр, тохон тохон, уут сав, гутал оймс, цув нөмрөг, дэвсгэр хаяавч гээд ер юм бүрийг хийж хэрэглэж иржээ.






Зураг 4. Төрөл бүрийн эсгий эдлэл

Эсгийний түүх монгол гэртэй салшгүй холбоотой. Нүүдэлчдийн амьдралын хэв маягт тохирсон бага жинтэй, илүү дутуугүй тавилга хэрэгсэлтэй, буулгаж барих, зөөж нүүхэд хялбар гэрийг бүтээхэд эсгий их үүрэг гүйцэтгэжээ. Гэрийн дээвэр, туурга, үүд, өрх, дэвсгэр, хаяавч зэрэг олон зүйлийг эсгийгээр хийдэг (зураг 5).

Ээрүүл бүдүүн, нарийн, дунд зэргийн утасных гэж гурван янз байдаг. Түүнийг дугуйны хүнд хөнгөн, том багаар тохируулна. Ээрүүл нь дугуй, иш хоёроос бүрдэнэ. Дугуйг чулуу, мод, төмөр зэрэг янз бүрийн зүйлээр хийх боловч голдуу модоор хийнэ. Бүдүүн утасны ээрүүлийн дугуй том, иш урт байна.

Дугуйг хийхдээ 2 см орчим зузааж хавтгай модыг 1-1,3 см зузаан болгон жигд дугуйлан засна. Бүдүүн утасны ээрүүлийн дугуй нь төвийн цэгээс зах хүртэл 5,5-6 см, дунд зэргийн утасных 4,5-5 см, нарийн утасных 3.5 -4 см хэмжээтэй байна. Бүдүүн утасны ээрүүлийн ишний урт 25, дунд зэргийнх 20, нарийн утасных 18 см урт байна. Ишийг нүхэнд бариу суухаар бүдүүнтэй, ардаа тээглүүр тавтай зорж, дээд үзүүрийг алсаас нарийсган үзүүрийг шовхлон засаад дугуйн доороос дээш шургуулж таванд тээглүүлэн тогтооно.





Зураг 5.Гэрийн эсгий хэрэгсэл (www.art-gallery.mn-ээс авав)



-Эсгийгүйгээр малчин бидний амьдрал ч үнэхээр бүтэшгүй юм аа. Би эсгийг зөвхөн гэрийн бүрээс, ширдэг төдийхнөөр л төсөөлж байж. Ноосоор ямар ч олон гоё юм хийдэг юм бэ. Яаж хийдэг юм бол... сурах юмсан. Эхлээд утас ээрч ширмэл ширж суръя.

Утас ээрч байгаа хүнийг харсан болохоос өөрөө ээрч үзээгүй юм байна шүү. Сурна даа. Харин ээрүүл... Тэр чинь ёстой манайд байхгүй дээ...






Ганаа Болороогийн олж бэлтгэсэн модоор эрүүл хийж эхлэв.



Дасгал 2. Суралцагч та ч гэсэн Ганааг дагаж ээрүүл хийгээрэй

а) Дунд зэргийн ээрүүлийн дугуй хийх хавтгай модны төвд тэгш хэмээр огтлолцсон 2 шулуун зураарай. (зураг 6,7)



Зураг 6,7. Ээрүүлийн дугуйн хэмжээг модон дээр зурсан байдал

Санамж: Гортиг, шугам байхгүй бол 7-8 см голчтой хундага, жижиг аяга, савны таглаа ашиглаарай.





б) Шулуунуудын огтлолцсон цэг дээр эхлээд өрөмдөх юмуу нарийн үзүүртэй хутгаар цоолоод, дараа нь улайсгасан нарийн төмрөөр нүхийг сэтгэн томсгоно.

в) Зургийн дагуу дугуйлж засна.

г) Эрүүлийнхээ ишийг зорно.

д) Иш дугуй хоёрыг угсарна (Зураг 8,9).



Зураг 8,9. Эрүүлийн иш болон дугуй, угсарч бэлэн болгосон ээрүүл

Хоёр цагийн дараа дунд зэргийн утасны ээрүүл бэлэн болов. Болороо ээрүүлийг барьж үзэн баярлана.

Манай өвгөн ч уран шүү хэмээн урамшуулна.

Ганаа тааламжтай инээмсэглэнэ.



Дасгал 3. Гар ээрүүл хийж дэлгүүрт тавибал борлох болов уу, ярилцаарай.



- Ээрүүл хийхэд хэдэн цаг зарцуулах вэ?
- Хэдэн төгрөгөөр үнэлэх вэ?
- Танай малчны бүлэгт ээрүүл хийж чадах хүн хэд байгаа вэ?
- Зарж борлуулсан мөнгөө "Дундын санд"-аа нэмэрлэх үү?

Гар ээрүүлийн давуу тал	Сул тал
Хямд, авсаархан	Хөдөлмөрийн бүтээмж бага
Гарын доорх материал ашиглана	
Материалын олдоц сайн	
Тог, цахилгаан шаардахгүй	
Ноосны хаягдал бага гарна	

Утас ээрэхэд гар ээрүүлээс гадна хөл буюу механик ээрүүл, цахилгаан ээрүүл хэрэглэдэг. Хөл ээрүүл нь нэлээд нарийн бүтэцтэй, том хэмжээтэй төхөөрөмж бөгөөд богино хугацаанд их утас ээрэх боломжтой. Хөл ээрүүл ээрэх хэсэг, утас ороох гол, гишгүүр, ноос тогтоох хэсгээс бүрдэнэ (Зураг 10,11). Ээрүүлээ өмнөө тавьж сандал дээр суугаад, хоёр гараараа ноосоо тасралтгүй цувьж, хөлөөрөө гишгүүр дээр гишгэн эргэлдүүлж ээрнэ. Хөл ээрүүл хийж нийлүүлдэг газрууд байдаг. Тэдний нэг нь “Хөх тэнгэр” гэдэг аж ахуйн нэгж юм. Хэрвээ Та тодорхой мэдэхийг хүсвэл дараах хаягаар харилцаарай.

Хаяг: Жижиг дунд үйлдвэрийн Баянзүрх төв

Имэйл хаяг: j_khuhtenger@yahoo.com

Албан утас: 96654914 , 99606019

Албан тушаал: Захирал

Овог нэр: Т.Болдбат

Гар утас: 96657805

Имэйл хаяг: tboldbat@yahoo.com



Зураг 10. Хөл ээрүүл (Орос)



Зураг 11. Хөл ээрүүл (Монгол, “Хөх тэнгэр”)



Утас ээрэхийн тулд юуны өмнө ноосоо бэлтгэнэ. Утсыг тэмээ, хонины ноос, ямааны ноолуур, сарлагийн хөөврөөр ээрдэг. Гэрийн бүрээс, монгол гутлын оймс, гудас, тохош, тохом зэрийг оёх утасны ноос төдийлэн боловсруулалт шаарддаггүй бол сүлжмэл болон эсгий эдлэлийн чимэглэл оёо, ширмэлийн утас нэлээд боловсруулалт шаардана.


Ноосонд энгийн боловсруулалт хийхлээ хог, шороо, өвс ургамлын хольцыг сайтар цэвэрлэн, бөөнтсөнийг задлан сэвсгэр болгохын тулд савандаж угаан хатаана. Хатсаны дараа дахин сэмэлж сэвсийлгэнэ. Дараа нь хялгас, зөөлөн нарийн ноосыг жигд хольж ээрэхэд бэлтгэнэ. Утсыг дан хялгасаар хийвэл зөөлөн юм оёход тохиромжгүйн дээр эрч нь амархан задрах төдийгүй учгийн зангилаа тогтдоггүй. Дан зөөлөн ноосоор ээрвэл утас хэврэг болдог. Иймд хольцыг тохируулна. Зогдрыг шөрмөс, олстой хольж томоод хөхүүр, ширэн дашмаг монгол гутлын уллагаа, уланд шир татахад хэрэглэдэг.


Зогдрыг бие ноостой жигд хольж, ээрэх утасны бүдүүн нарийнд тохируулан цувж утсыг ээрнэ. Нэхмэлийнхийг сулхан, оёдолд хэрэглэх утасны эрчийг гүйцээж ээрвэл зохимжтой. Утсыг дараах дарааллаар ээрнэ. Үүнд:

1. Ээрэх ноосноос бага зэргийг цувж, имэрч эрчилнэ.
2. Эрчилсэн үзүүрийг ээрүүлийн ишинд бэхэлнэ.
3. Утсыг ишний дагуу татаж, ишний үзүүрт хүргээд хуруугаа орооно.
4. Ороогоод үүссэн гогцоог ишний үзүүрт оруулан чангална.
5. Цувсан ноосоо зүүн гартаа барьж, баруун гараараа ээрүүлээ эргүүлэн ээрнэ. Цувамлаа эхлээд ээрүүлийн үзүүрт ойрхон барьж бага багаар ахиулсаар нэг удаа эрчлэх хэмжээнд хүргэхгүй бол ноос тасарна гэдгийг анхаараарай.
6. Эрчийг хүссэн хэмжээнд хүргэн гүйцээж ээрнэ.



Дасгал 4. Дээрх дарааллын дагуу утас ээрэх дасгал хийгээрэй. Дасгалаа хийхдээ зураг 12-17-г хараарай






Зураг 12, 13, 14, 15, 16, 17. Гар ээрүүлээр утас ээрэх арга

Утас ээрээд сурчихлаа. Одоо ширмэл ширж сурна даа. Ганаа маань ч дэмжиж байгаа бололтой. Цаашдаа ширмэлийн эсгий хийх, эсгэх, зурах гээд тусламж их хэрэгтэй болох нь. Ганаа ч туслах байх.



Ширмэлийн эсгийг бэлэн эсгий сонгох юмуу эсвэл ширэх зүйлдээ тохируулан дарж бэлтгэнэ. Бэлэн эсгийг сонгохдоо суналт, агшилт багатай, элдэв толбо согоггүй, ширээс сайн гарах байдлыг харна. Эсгий нь ширэх эдлэлд бүрэн хүрэхээр зүйдэлгүй байвал сайн. Ширмэлд зориулж эсгий дарах аргын талаар товч өгүүлье.



а. Зулах арга. Самнасан буюу сэмлэж бэлтгэсэн ноосоо 2 тэнцүү хэсэгт хуваана. Эхний зулалтыг үлгэрээсээ хааш хаашаа 3 хуруу илүү хөндлөн, хоёрдугаар зулалтыг босоо бөгөөд эхний зулаатай яг чацуу зулна. Маш жигд онгорхой сиймхийгүй зулна. Эсгийг бөх, суналт агшилт багатай болгохын тулд нэг, хоёрдугаар зулааны хооронд самбай тавьж болно.



Зураг 18,19. Ноос зулж буй байдал

б. Эсгийрүүлэх арга. Зулаагаа ноосыг нь хөдөлгөхгүйгээр тюль (тор) -ээ хөндий барьж бүтээгээд, бүлээн усаар шүршин норгоно. Бүх талбайг савантай гараар 15 минутын турш зөөлөн илж дарна (зураг 20).

Дараа нь гулууз модонд ороон өнхрүүлэн бэхжүүлнэ. Эсгийгээ улам нягтруулахын тулд гулууз модоо авч, халуун усанд (10-15 минут) байлгаад илэх, үрэх, өнхрүүлэх, татах ажиллагааг давтан хийнэ (зураг 21). Хүссэн хэмжээ гарсан эсэхийг үлгэртэй харьцуулж шалгана. Жижиг байвал сунгаж татна, том байвал дахин нягтруулж агшаана. Нягтруулж эсгийрүүлсэн нойтон эсгийгээ цэвэр бүлээн усаар саванг нь гартал угааж, татаж дэлгэн хатаана.




Зураг 20. Савантай гараар илж буй нь



Зураг 21. Гулууз модонд ороон нягтруулж буй нь

Монгол уламжлалаар эсгий ширмэлийг гурвалж, дөрвөлж, наймаалж тавьж нүдэлж



ширдэг. Хээ тавихдаа эхлээд хөндлөн, дагуу, жишүү гурван шугам татаад, тэр тэнхлэгээс хоёр тийш хэмжиж хээний хүрээлбэрийг гаргаад, дотор нь хувааж хуваарлин сүлжээ холбоо шүтэлцээнд урлах хээлэх ажгуу. Дүгрэг, дөрвөлжин хээн дотор хичнээн ч хошуулж нүдэлж болно (Л.Батчулуун, 1999).



Зураг 22. Голдоо цэцгэн хээтэй, захаар нь гурвалж нүдэлж ширсэн ширдэг



Зураг 23. Голдоо арслан хээтэй, захаар нь угалз болон гурвалж нүдэлж ширсэн ширдэг

Болороо айлынхаа Урнааг ятган хоёулаа нэг нэг олбог ширэхээр болов.



Дасгал 5. Жижиг олбог ширэх дасгал хийгээрэй



а) Дараах загваруудаас сонгоорой (зураг 24)







Зураг 24. Ширмэл олбогны загварууд

- б) Сонгосон загварынхаа хээг цаасан дээр зураарай
- в) Цаасан дээр зурсан хээгээ дагуулан бүдүүн зүүгээр цоолоорой
- г) Цоолбороо эсгий дээрээ байрлуулаад шидэж тогтоогоорой
- д) Цоолборын нүх бүрийг эсгий дээрээ балын харандаагаар тодруулаарай.
(Тосон бал мэтийн дараа нь арилахааргүй үзэг, харандаа бүү хэрэглэ.)
- е) Зургаа дагуулан, утасныхаа таталтын сул чангыг тааруулан жигд хатган ширээрэй (Зураг 25, 26, 27, 28)





Зураг 25, 26, 27, 28. Эсгий дээр хээ буулгаж ширж эхлэх байдал

ж) Ширж дуусаад олбогоо даавуугаар доторлож шидээд, хүссэн өнгөөрөө загварт харуулсан шиг ирмэгийг нь хүрээлээрэй

з) Бусдын бүтээлтэй харьцуулаарай (зураг 29, 30)



Зураг 29. Ширмэл олбогны загварууд



Зураг 30. Машины суудлын бүрээс

Уран бүсгүйчүүдэд санал болгох бас нэг санаа байна. Хүн ер нэг төрлийн үйлээс уйдамтгай амьтан шүү дээ. Бас ширдэг ширэхээс ч илүү нарийн урлалаар өөрийгөө сорих хүсэл ч төрөх юм билүү? Гэхдээ ширмэл ширж хэрэгцээгээ хангах, ашиг олох санаагаа бүү орхиорой:

Зүү ороох оёдол бол манай уламжлалт гар урлалд томоохон байр суурь эзэлдэг. Зүү ороох оёдлыг төрөл бүрийн хувцасны гоёл чимэглэл, ахуйн эд зүйл, хатгамал урлагийн бүтээлд өргөн ашигладаг (Зураг 31, 32).






Зураг 31. Хоёр өөр өнгийн утсаар оёсон зүү ороох оёдол



Зураг 32. Нэг өнгийн утсаар оёсон зүү ороох оёдол

Зүү ороох оёдлыг хялбар аргаар гүйцэтгэх нэг аргыг зургаас харж оёж сураарай. Эхлээд даруулах оёогоо жигд нямбай оёд, дараа нь зурагт заасан маягаар ороож оёно (зураг 33).






Зураг 33. Зүү ороох оёдлыг гүйцэтгэх арга

Аль ч аргаар оёсон даруулах оёдлыг маш жигд нямбай оёвол үзэмжтэй болно. Зүү ороох оёдол нь өнгөний хослол, уусгалт, зохицлыг дээд зэргээр шаарддаг оёдол юм. Хичнээн сайхан нямбай оёлоо ч утасны өнгө, бүдүүн нарийн нь тохироогүй бол зүү ороох оёдол сайхан болохгүй. Мөн хээлэх хээ угалзын сонголт болон тэдгээрийн байрлал, зохиомж ч их чухал.



Зураг 34. Зүү ороох оёдлоор чимэглэсэн даалин, гутал, оймсны хараа



Өнгө донж, хээ угалзыг нь тохируулж зүү ороох оёдлоор оёсон 1 дайлан цагаан сарын үер хамгийн доод тал нь 100 мянган төгрөг хүрдэг, гурван сарьстай, зүү ороох оёдлоор чимэглэсэн, монгол гутлыг оёх ажлын хөлс 1 сая 800 мянган төгрөг байдаг гэнэ. Та өөрийгөө сориод үзэх юм биш үү!...

Эрдэмтний үг



“Хоосрохуйд урьдаар ухаан барагдана. Ухаан барагдахын шалтгаан нь залхуурал”

Бат-Очирын Тогтохтөр (1797-1868)



Монгол улсын төрийн соёрхолт, Гавьяат багш, биологийн шинжлэх ухааны доктор Н. Эрдэнэцогт

Чөдөр ногт зангидах, хазаар эмээл төхөөрөх, морио уургалан барьж, унааны найдвартай хүлэг болгон сургах гээд аавын хийж чаддаг бүхнийг хөвгүүд сурна. Харин охид дээл оёх, сааль сүү хийх, дайлах цайлах мэтийг ээжээсээ сурна. Ямар ч багш, зааварлагчгүй хэрнээ эсгий монгол гэрт нүүдлийн соёлын сургалт ингэж тасралтгүй залгамжлан явагддаг. Тэнд олон жижиг үйлдвэрлэл бас дараа үедээ өвлөгдөнө. Малчны гэрт төрөөд, малын дэргэд өсч өндийсөн хүмүүс ясны хөдөлмөрч, их тэвчээртэй болдог.


4. НЭХИЙ ЭЛДЭХ ДАСГАЛ



Дасгал 6. Ганаа, Болдоо хоёртой хамт нэхий элдэх дасгал хийгээрэй

САНАМЖ

Элдүүр сайхан болоход арьс, нэхийний чанар их нөлөөтэй. Үхсэн буюу нядалсан малынхаа арьс, ширийг буруу ярж, халим хальс үлдээн өвчих, огтолж исгэх, нар салхи, ус чийгтэй газар хадгалах зэргээр чанарыг нь муутгахгүй байхад анхаараарай.



1. *Нэхий элдэх ажлын дараалал, анхаарах зүйлийг хүснэгт 1-ээс хараарай*

Хүснэгт 1. Нэхийг монгол аргаар гандаж элдэхэд гүйцэтгэх ажлын дараалал, анхаарах зүйл

Ажлын дараалал	Гүйцэтгэх ажилбар	Анхаарах зүйл
1. Арьс, нэхийг гандахад бэлтгэх	а. дэвтээх б. угаах в. халимлах	Шар мах өөхийг сайн цэвэрлэнэ Хэт халуун усанд угааж болохгүй.
2. Гандах	а. ган хийх б. гандах	Ойр ойрхон хөдөлгөж байна.
3. Гангаас гаргаж хатаах	а. мушгих б. сэгсрэх в. тэнийлгэж хатаах	Сүүдэрт хатаана.
4. Элдэх	а. хэдрэгдэх буюу талхих б. хянгардах в. зүлгэх	Урах, зүсэх, туламтахаас сэргийлнэ.

2. *Элдэх нэхийгээ зааврын дагуу дэвтээгээрэй*

Шанага усанд хоолны 1 халбага давс байхаар бодож уусмал бэлтгэнэ. Уусмалын хэмжээ дэвтээх арьс, нэхийний тооноос хамаарна. Арьс, нэхийгээ дэвтээхээс өмнө сайн гөвж сэгсрэн хог шороог нь цэвэрлэнэ. Дараа нь бэлтгэсэн уусмалдаа арьсаа нэг талаас нь эхлэн далд ортол дүрж дэвтээнэ.



3. *Дэвтээсэн нэхийгээ угаагаарай*



Тохой дүрж үзэхэд дөнгөж бүлээн усанд үс, хөрсний бохирдлыг арилтал угаана. Саван, сод зэрэг угаагч өнгөлөгч бодис хэрэглэж болно.



4. Угаасан нэхийний өөх махны үлдэгдлийг цэвэрлээрэй



Нэхийний өөх, махны үлдэгдлийг хутга, хянгараар хусаж сайн цэвэрлэнэ. Арьсны хөрсийг зүсэж гэмтээхгүй байхыг онцгой анхаарна.

САНАМЖ

Нэхийг хатуу усаар угаавал үс нь шарлаж, хөрс нь хугарамтгай болох учир усаа зөөлрүүлэх хэрэгтэй.

Усаа зөөлрүүлэхийн тулд 10 литр усанд хоолны халбагаар нэг сод хийнэ. Мөн усаа буцалгаж хөргөөд угааж болно.

5. Нэхийгээ гандах ган бэлтгээрэй

Ганг усан ган, айргийн ган гэж ангилдаг боловч нутаг нутагт өөр өөр өвөрмөц онцлогтой байдаг. Усан ганг шар будаа, хоолны давс, усаар бэлтгэнэ. Айргийн ганг зурагт үзүүлсэн орцоор бэлтгэнэ.



6. Угааж бэлтгэсэн нэхийгээ гандаарай

Гандах арьсаа нэг талаас нь дүрэх маягаар ган руу хийнэ. Өдөр бүр 2-3 удаа сайн хутгана.

Нэхий 5-6,


ямааны арьс 4-5,

хурга, ишигний арьс 3-4

хоногт ган орно.



Арьсны гоцыг гангаас ил гарган 30-40 минут болгоод, хөндлөн чиглэлд татаж үзэхэд цайрч байвал ган сайн орсон гэж үзнэ.



7. Гандсан нэхийгээ гаргаарай

Гандсан арьс, нэхийд ган орсон эсэхийг сайн шалгаад, гаргаж хатаана. Хатаахдаа дараах зүйлийг анхаарах нь чухал. Үүнд:

- Сайн мушгиж сэгсэрнэ.
- Үсийг нь бүрэн, хөрсийг нь өлөн чийгтэй болтол хатаана.
- Сүүдэр газар хэцэн дээр тохно.






8. Гандсан нэхийгээ элдээрэй

Арьс шир боловсруулах ажлын хамгийн уйгагүй, хүч хөдөлмөр шаардах ажиллагаа нь элдүүр. Бод малын шир, том нэхий арьсыг эрэгтэйчүүд, хурга ишигний арьсыг эмэгтэйчүүд голдуу элддэг. Элдүүр хийхэд хэрэглэгдэх авсаархан багаж, төхөөрөмжийг гэрийн нөхцөлд хийж хэрэглэнэ.


Хүснэгт 2. Элдүүрийн багаж хэрэгсэл

Багажны нэр	Зориулалт
1. Хэдрэг 	Нэхий элдэх гол багаж хэдрэгний ир амархан илэгддэг учир сухай, хус мэт хатуу модоор хийдэг. Хэдрэг тодорхой заасан хэмжээгүй боловч арьсыг хэдрэгдэх хүн хөлөө жийж суугаад хэдрэгээ хөндлөн барихад баруун гар өлмийд, зүүн гар гуяны зузаан булчин орчимд байхаар уртыг тохируулна.
2. Хянгар 	Хэдрэгдсэний дараа нэхийний суларсан хөрсийг хянгараар хусч цэвэрлэнэ. Хянгарыг хатуу төмрөөр хийнэ. Тогтсон хэмжээ байхгүй боловч урт нь 20 орчим сантиметр, өргөн 10-12 сантиметр орчим байдаг.
3. Хиур 	Хоёр талдаа иртэй, нэхий хусах, хянгардах зориулалттай урт төмөр хусуур. Хиур барихад тохиромжтой, их талбай хусдаг сайн талтай.



4. Талхи (халх) 	Нэхийг хэдрэгдэхэд нэлээд хүч цаг зарцуулдаг. Энэ ажлыг хөнгөвчлөхийн тулд талхийг ашигладаг. Талхийг хийхдээ хоёр банзыг зэрэгцүүлэн байрлуулж хоёр хөндлөн модоор үзүүрийг нь зөрүү холбоно. Түүндээ даруулга мод тохируулана.
5. Хөл дэгүүр 	Дээрээ бариултай, доороо хөлийн өлмийд угладаг гогцоотой, бариулын доод талд доошоо харсан ац гарган ацны хооронд хадуурын төмрийн үзүүр буюу түүнтэй адил хэлбэртэй төмөр хусуур хийдэг. Хөл дэгүүрээр хусахдаа арьсны урд хоёр год, хүзүүний арьсыг модонд бэхэлж, дэгүүрийн гогцоог хөлийн өлмийд углан баруун гараар дээд бариулаас барьж дээш доош гүйлгэн хусна.

9. *Нэхийгээ хэдрэгдээрэй*





Хэдрэгдэхийн өмнө хэдрэгээ сайн ирлэнэ.


Нэхийний дөрвөн годоор нь эсвэл хүзүүний арьсыг хоёр хөлийн өлмийн завсар хавчуулан хэдрэгдэнэ. 15 минут орчим арьсны бүх талбайд 8-10 дахин хэдрэгдээрэй. Тэгшхэн газар тавьж, хойт 2 годыг хоёр тийш нь сайн татаж хэдрэгээ дээр нь хөндлөн тавьж, дээр нь өвдөглөөд арьсаа хөндлөн тууш сайн татаж сунгана. Тэнийлгэсний дараа эвхэж гадуур нь шуудай эсвэл даавуугаар боож чийг алдахааргүй хадгална.

10. *Нэхий талхидах аргатай танилцаарай*

Ямар талхи хэрэглэж байгаагаас хамааран талхидах арга бага зэрэг өөр. Халх талхиар талхидахад талхидах арьсаа нарийхан нугалан хөндлөн бариад даруулга модоор олон дахин дарна. Дарах бүртээ арьсаа эргүүлнэ. Талхидах үед талхийг хөдөлгөөнгүй байлгахын тулд хүнд чулуу тавьж, гэрийн хана буюу хашаатай бэхэлнэ. Талхидах нь арьсыг хэдрэгдэж элдэхээс хялбар, хөдөлмөр хөнгөвчилдөг арга юм.



11. Нэхийгээ хянгардаарай




Элдүүр нь ханаж байгаа нэхийг хурц хянгараар маш зөөлөн хусч махан хөрсийг авч дууссаны дараа цаас шиг цагаан, торго шиг зөөлөн болно.

Элдсэн нэхийг сэгсрэхэд даржигнасан дуу чимээ гарахгүй, хөрсөн дээр нь гарын алгаар дарахад сэрүү татахгүй бүлээн оргиж байвал элдүүр ханасны шинж.

12. Нэхийгээ зүлгээд, татаж дэлгээрэй

Элдүүр ханасан арьсыг нарийн зүлгүүрээр зүлгэж хөрсийг жигдрүүлээд тал тал тийш нь сайн татаж, дэлгэнэ.



Өөрийгөө үнэлээрэй.

Дараах асуулт бүрээр өөрийгээ үнэлж, онооны тоог дөрвөлжин дотор бичээрэй. Хариултад харгалзах онооны тоог дороос харна уу.


Тийм	2 оноо	-	Би сайн сурсан
Бараг тийм	1 оноо	-	Би дунд зэрэг сурсан
Үгүй	0 оноо	-	Би сурч чадаагүй



Д/д	Асуулт	Хариулт
1	Та нэхий дэвтээж, угаахад анхаарах зүйлийг мэдэх үү?	☐
2	Ган хийхэд орох зүйлийг мэдэх үү?	☐
3	Ган хийж нэхий элдэж үзэв үү?	☐
4	Хэдрэг, хянгар, талхи байгаа юу?	☐
5	Нэхий элдэх багажаа та өөрөө хийсэн үү?	☐
6	Та одоо нэхий элдэхийг бусдад зааж өгч чадах уу?	☐
7	Та элдсэн нэхийгээ суралцагчдын бүтээлийн үзэсгэлэнд тавьж бусдаар үнэлүүлэхэд бэлэн байна уу?	☐
8	Нэхий элдэх үйлдвэрлэл- үйлчилгээ явуулах тооцоо хийж үзсэн үү?	☐
9	Хэрэв хийсэн бол ашигтай ажиллаж чадахаар байна уу?	☐

Та нийт хэдэн оноо авсан бэ?

Нийт оноо	Үнэлгээ	Таны боломж
17-18	сайн	Та нэхий сайн элдэж сурсан байна. Цаашдаа нэхий элдэж өрхийнхээ орлогыг нэмэгдүүлэх боломж байна.
15-16	дунд	Хичээлээ эргэж үзээрэй. Дадлага ажлаа дахин хийгээрэй. Сайн сурсан зарим хүмүүсээс туршлага судалж болно. Танд ирээдүй байна.
13-14	хангалтгүй	Та модулиа эхнээс нь сайн анхааралтай үзэж, бүх дадлага ажлыг хийгээрэй. Танд бусдын адил амжилтад хүрэх боломж байна.






Хүүхэдтэйгээ ярилцаарай

- Ааваа та ёстой сайхан чөдөр хийлээ, тийм ээ?
- Сайхан болсон байна уу?
- Сайхан
- Энэ модоор хийснийг юу гэдэг вэ, миний хүү, мэдэх үү?
- Чагт гэдэг
- Хэдэн чагт байна вэ?
- Гурав
- Тэгвэл хаа нь аль вэ?
- Мэдэхгүй, мал шиг хаатай юм уу? Энэ хоёр нь хаа нь, энэ хойт талынх нь гуя юм уу?
- Чөдрөнд гуя байхгүй. Аав нь зураг дээр заагаад өгье. Сайн тогтоож аваарай.
- За





Чөдрийн баруун хааны урт нь 9-10 сантиметр, зүүн хаа нь 7-8 сантиметр, өөрөөр хэлбэл зөв талын хааны урт нь арай богино байдаг.

5. ШАР СҮҮ, ДАЙВАР БҮТЭЭГДЭХҮҮНЭЭР ТӨРӨЛ БҮРИЙН ХООЛ ХҮНС БЭЛТГЭХ ДАСГАЛ АЖИЛ

Шар сүүгээр ундаа, чанамал, ирис зэрэг олон төрлийн бүтээгдэхүүн хийж болдог. Та тэдгээр бүтээгдэхүүнийг хийж сурмаар байна уу?



Дасгал 7. Дараах жорын дагуу төрөл бүрийн хоол хүнс бэлтгээрэй

Шар сүүгээр бүтээгдэхүүн хийх дасгал ажил. Шар сүүгээр бүтээгдэхүүн хийхийн тулд сайтар тунгалагжуулах шаардлагатай. Үүний тулд дараах аргыг хэрэглэнэ.



- Сүүний машинаар 2 дахин машиндана.
- 1-2 цаг буцалгана.

- Хөргөөд шүүнэ.



Шар сүүн чанамал

- Тунгалагжуулсан шар сүү, элсэн чихэр хоёрыг тэнцүү хэмжээгээр авч авч, чихрээ уустал хутгаад, буцалгана.
- 50 г шар сүүнд 100 г крахмал (төмсний гурил), 10 г дээд гурил хийж хутган үндсэн хольцондоо нэмж дахин зөөлөн гал дээр өтгөртөл нь буцалгана.
- Хөргөөд жимсний шүүс нэмж хийнэ.



Шар сүүн ундаа

1 литр тунгалагжуулсан шар сүүн дээр 80 г элсэн чихэр хийж буцалгаад сайн хөргөнө. Дараа нь 1 литр буцалсан ус, өөрөө бэлтгэсэн жимсний шүүс буюу бэлэн сироп амталгааныхаа хэмжээгээр нэмнэ.



Шар сүүн ирис чихэр

500 г шар сүү, 500 г саахар, 15 г крахмал (төмсний гурил), 20 г хуурсан гурил 15 г ванилин хийж сайн хутгаж холиод зөөлөн гал дээр 1-2 цаг буцалгаж тогтмол хутгана.



Шар сүү мармелад (царцмаг)

400 г шар сүүнд 100 г желатин хийж хоёр цаг дэвтээнэ. Дахиад нэмж 600 г шар сүү, 400 г элсэн чихэр, нэг уут ванилин хийж зөөлөн галаар 10 орчим минут буцалгаж хутгана. Дээр нь жимсний шүүс нэмж хийгээд хэвэнд царцаана.

Байцаа, гүзээний зууш

Цэвэрлэж зумалсан гүзээг хүйтэн усанд хийж чанаад хөргөнө. Хөргөсөн гүзээ, цэвэрлэсэн байцаа, лууван, сонгиныг нарийхан хэрчиж бүгдийг нийлүүлээд хоол амтлагчаар амтална.


Орц: Малын гүзээ 160 г, шар лууван 13 г, бөөрөнхий сонгино 12 г, байцаа 50 г, хоол амтлагч 20 г, чимх давс



Сархинагийн зууш

Цоохор сархинагийг угааж, хусаж сайн цэвэрлээд зөөлөртөл нь чанаж хөргөнө. Хонины сүүлийг тусад нь чанаж хөргөнө. Хөргөсөн сархинаг, хонины сүүлийг нарийхан хөшиглөөд давс, повоор, жижиг хөшиглөсөн сонгиноор амт оруулан хольж найруулна. Ийм зуушийг хальсалж угаагаад дэрс маягаар хөшиглөсөн шар луувангаар хачирлаж өгнө.

Орц: Сархинаг 2, сүүл 80 г, шар лууван 1, сонгино 1, чимх давс, повоор (хоол амтлагч)



Бөөрөн зууш

Бөөрийг бага зэргийн цагаан цуу хольсон бүлээн усаар 2-3 дахин угааж цэвэрлээд чанана. Чанаж байхдаа усыг 2 дахин солино. Чанаадхөргөсөнбөөр, өргөстхэмх, бөөрөний сонгиныг нимгэн хавтгай хөшиглөн бүгдийг нийлүүлж холиод давс, повоороор амтлан хольж бэлэн болгоно.

Орц: Бөөр 400 г, сонгино 1, өргөст хэмх 300 г, чимх давс, повоор (хоол амтлагч)



Элгэн хиам

Элгэн хиаманд орох бүтээгдэхүүнийг урьдчилан чанаж болгоно. Чанаж гаргасан элэг, дэлүү, уушги, мах, өөх, чацархайг жижиглэн махны машинаар машиндана. Дараа нь амт оруулагчаар амтлаад сайн хутгана. Машиндсан шанзандаа дээрх бүтээгдэхүүнийг чанахад гарсан шөлийг хийж дахин сайн хольж хутгаад нарийн гэдсэнд шахна.

Хиамыг 30-35 орчим см урттайгаар хэсэглэн эрчлээд 60-75 орчим хэмтэй (буцлах шахсан) шөл эсвэл усанд хийж 2-3 цаг байлгана. Энэ үед хиамыг тогоочийн зүүгээр үе үе хатган хийг гаргаж байх ба бэлэн болсон үед хиамыг хатгахад тунгалаг шингэн гарна. Энэ үед хиамыг шөлнөөс нь гаргаад хүйтэн усанд хийж, 5 минут байлгаад гаргана. Бэлэн болсон хиамыг нэг хонуулаад хүнсэнд хэрэглэнэ.

Нэг кг элгэн хиам бэлтгэхэд шаардагдах орц:



1. Элэг	200 г
2. Дэлүү	50 г
3. Уушги	50 г
5. Мах	200 г
6. Чацархай	50 г
7. Нунтаг повоор	10 г
8. Улаан чинжүү	10 г
9. Цагаан будаа	150 г
10. Шөл	180 г
11. Өөх	300 г
12. Сонгино	30 г



Цусан хиам

Цусан хиаманд орох бүтээгдэхүүнийг халуун ус эсвэл шөлөнд хийж болтол чанана. Чанасан бүтээгдэхүүнийг жижиглэн хэрээд чинжүү, гоньд, повоор, давс, шарсан бөөрөнхий сонгино зэргийг хольж махны машинаар машиндана. Бэлтгэсэн шанзанд шингэн цусаа хийж сайн хутгаад бог малын бүдүүн гэдсэнд шахна. Энэ хиамыг элгэн хиамны адил 30-35 см-ийн урттай хэсэглэн эрчилнэ.

Цусан хиамыг 60-75 орчим хэмтэй (буцлах шахсан) шөл буюу усанд 2-3 цаг байлгаж болгоно. Цусан хиамыг тогоочийн зүүгээр хатгахад цус гарч байвал болоогүй харин тунгалаг шингэн шүүс гарч байвал болсон гэж үзнэ. Цусан хиамыг шөлнөөс гаргаж, хүйтэн усанд хийж 5 минут байлгаад гаргаж хөргөнө. Хиамыг сэрүүн газар нэг хонуулаад хүнсэнд хэрэглэнэ.

Нэг кг цусан хиам бэлтгэхэд шаардагдах орц:

1. Уушги	80 г
2. Дотор мах	200 г
3. Мах	250 г
5. Гадар өөх	150 г
6. Цус	200 г
7. Цагаан будаа	180 г
8. Чинжүү	15 г
9. Гоньд	5 г
10. Нунтаг повоор	10 г
11. Давс	25 г
12. Бөөрөнхий сонгино	30 г



Дасгал 8. Ааруул хуруудаа хэвлэж төрөл бүрийн хэлбэр оруулахдаа дараах зургуудаас санаа аваарай.




6. АМЖИЛТ БҮТЭЭЛ

Ганаагийн хот айлынхан ёстой л үйлдвэрлэгч хот айл боллоо. Болороо, Урнаа хоёр ширмэл ширж, цагаан идээгээ боловсруулан, дайвар бүтээгдэхүүнээр төрөл бүрийн амтат хоол зууш хийнэ. Ганаа, Болдоо хоёр арьс элдэж, чөдөр ногт зангидана. Сургалтын тайлан-үзэсгэлэнд тавих бүтээгдэхүүнүүд бэлэн болж байлаа. Батаа, Болдоогийн хүү хоёр аавууддаа тусалдаг, Булгаа охин ээж Урнаа эгч хоёрыгоо үйл мэтгэж байхад дэргэд нь сууж удаанаар ажиглах ба утас зүү ойртуулах, зүү сүвлэх зэргээр тусална. Тэд оройд ажлаа дуусгаад малчны бүлэг байгуулах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, малын тоног хэрэгслийн дэлгүүр нээх, хэн хэнийг элсүүлэх талаар ярилцах болов. Нэг орой малчдад зориулан үйлдвэрлэн бүтээх зүйлийн жагсаалтыг гаргав.

Малчдад зориулсан бүтээгдэхүүний жагсаалт:

- эмээл, хазаар
- чөдөр, ногт
- уурга
- шилбүүр
- араг савар
- чөдрийн чагт
- тохош
- тэмээний буйл
- модны ураар хийсэн халбага
- хөхүүрийн хараа
- ааруулын дэлгэц
- уур нүдүүр
- сур
- дээс, хошлон
- бурантаг
- ээрмэл утас гэх мэт олон зүйлийг жагсаагаад малчдын бүлгийн гишүүдийн хүчээр хийж чадахыг нь тодруулан зурав.



Тэр оройг ажил хэрэгч, бүтээлч уур амьсгалтай болгохын тулд Болороо, Урнаа хоёр сайн бэлтгэжээ. Тэд шар сүүгээр ундаа, чанамал, ирис чихэр, өглөө төхөөрсөн хониныхоо гэдсээр хиам, зууш хийж тавьсан байлаа. Хэвлэсэн ааруул, хатаасан өрөм байна. Ер бусын тансаг ширээг хараад хүүхдүүд:

- Ээжээ ямар баяр болох гэж байгаа юм бэ? гэнэ. Ганаа:
- Өглөө хонь гаргая гээд байхаар нь манай эхнэр их л өлсөж ядарсан юм байхдаа гэж бодсон, ийм учиртай юм байжээ гэв. Ёстой “үнэг гүйцэх нь” суугаад ид л биз дээ?
- Түр хүлээж бай, эрчүүд ээ, одоо Адиа ирэх байх. Сургалтынхаа үр дүнг багшдаа бодитойгоор үзүүлье гээд урьсан юм. Болдоо:
- Та хоёр ч ёстой юмыг зохион байгуулдаг хүмүүс юмаа, болж байна шүү.

Адиа ч ирлээ. Бүгдээрээ ширээ тойрон сууцгааж, оройн зоог барив. Хүүхдүүдэд шар сүүгээр хийсэн ундаа, эрчүүдэд элгэн хиам, Адиад цагаан идээ илүү таалагдлаа.

Ширмэл олбог, ээрсэн утас, ээрүүл, элдсэн нэхий, зангидсан чөдөр зэрэг залуусын бүтээсэн зүйлийг Адиа ихэд үнэлэв. Ганаа малчны бүлэг байгуулах төлөвлөгөөгөө танилцуулж, бусад нь санаагаа нэмэв. Адиа:

- Та нар дундын сангийнхаа журмыг л сайн ярилцаж тохир. Зарцуулалтын тайланг хэрхэн гаргаж, гишүүддээ танилцуулж байх талаар сайн оруул. Нэг нэгэндээ үл итгэх явдал гарах бий. Өнөөдөр урьдчилсан тайлан хамгаалалт боллоо. Малчны нэг шинэ бүлэгтэй, хэрхэн хамтран ажиллах төлөвлөгөөтэй болох нь шиг байна. Сайхан юм ярьж ярьчихаад мартчихуузай. Бүлгээ заавал байгуулах хэрэгтэй. Ярих хийх хоёр өөр шүү. Сумынханд тайлангаа тавих бэлтгэлээ сайн хийгээрэй хэмээн захиад Адиа гэртээ харихаар гарав.



-Ярьж төлөвлөж байгаа бүхнээ биелүүлчихээд ирэх жилийн өдийд багшдаа тайлангаа тавина аа.


-За тэгээрэй. Хэрвээ хүсвэл, бүтэхгүй юм гэж байхгүй. Одоо ч та нар амжилт бүтээл арвинтай байна.



-Болдоо, Урнаа бид дөрөв ч буцахгүй л гэж бодож байгаа. Бүлгээ заавал байгуулна, малчны дэлгүүрээ ч бас нээнэ. Хичээнэ ээ, Адиа. Бид нар Танд их баярлаж байгаа шүү. Бүлэг байгуулахад ч Та л бидэнд түшиг болно.



Хэдэн хоногийн дараа Ганаагийн хот айлынхан сумын төвд сургалтын Тайлан үзэсгэлэнд оролцов. Ганаа сурсан зүйлээ сумын иргэдэд ярьж, малчдын бүлэг байгуулах төлөвлөгөөгөө танилцууллаа. Сум, багийн удирдлагууд Ганаагийн хот айлынхны санаачилгыг сайшааж, дэмжихээ амлав. Болороо, Урнаа хоёр ширсэн олбог, ширдэг, элдсэн нэхий, цагаан идээ, шар сүү, дайвар бүтээгдэхүүнээр хийсэн хоол хүнсээ сумынхандаа үзүүлж, амтлуулав. Бас заримыг нь борлуулж, захиалага ч авлаа. Тэдний сурсан, бүтээсэн зүйлийг хүмүүс ам амандаа магтаж байлаа. Бусад багийн



суралцагчдаас сурах, санаа авах юм ч их байх аж. Амжилттай суралцаж төгссөн суралцагчдад багш нар нь гэрчилгээ гардуулав. Адиа Ганаад гэрчилгээ гадуулахдаа “Энэ зөвхөн эхлэл шүү. Цаашдаа улам сайн суралцаарай” гэлээ. Харин Болдоод гэрчилгээ гардуулахдаа “Энэ удаагийн сургалтаар онцгой ахиц дэвшил гаргасан хүн бол манай Болдоо. Урьд нь та бүхэн Болдоог халамцуу, согтуу явж байгааг нь харж байсан байх. Харин ажил хийж байгааг нь харсан нь хэд бол. Энэ торго шиг зөөлөн, цас шиг цагаан нэхийнүүдийг Болдоо элдсэн юм. Чөдөр, ногт гээд цаана нь ч зөндөө юм байна” хэмээн магтахад Болдоогийн нүд нь гэрэлтэж, их баярлаж байгаа нь илэрхий байлаа.



*Урмын үгээр мялаалгасан залуус улам
ихийг бүтээх хүсэл өвөртлөн гэрийн зүг
баяртай буцав.*

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Батчулуун Л., **Монгол эсгий ширмэлийн урлаг**, УБ., 1999
2. Гүндэгмаа Д., **Үйл бүтэг-1**, УБ., 2011
3. Гүндэгмаа Д., **Үйл бүтэг-2**, УБ., 2011
4. Гүндэгмаа Д., **Элдүүр зөөлөн болог**, УБ., 2011
5. Гүндэгмаа Д. нар, **Билгийн нүд-2**, УБ., 2005
6. Гүндэгмаа Д. нар, **Буянт малын арьс шир**, УБ., 1996
7. **Монгол ахуй** (үзэсгэлэн), УБ., 2006
8. Нямбуу Х. **Монгол угсаатны зүй**, УБ., 1973
9. Хөхөө Д., нар, **Зөв зангидаж сурвал ч...** УБ., 2009
10. <http://nova.rambler.ru>
11. www.google.ru



ХӨДӨӨ АЖ АХУЙН
ҮЙЛДВЭРЛЭЛД
ШИНЖЛЭХ
УХААНЫ ОЛОЛТ
НЭВТРҮҮЛЭХ ТӨВ

Монгол Улс
Улаанбаатар хот-15141
Чингэлтэй дүүрэг #60/1 байр
Утас/факс: 976 70118087
Вэб сайт: <http://www.naec.mn>
И-мэйл: info@naec.mn

ОЛОН УЛСЫН
ХӨДӨЛМӨРИЙН
БАЙГУУЛЛАГА

НҮБ-ын байр, Өрөө 209
Нэгдсэн үндэстний гудамж
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар 14201,
Монгол Улс
Утас: 976 11 320624
Факс: 976 11 320625
<http://www.ilo.org>